

# **2021 оны үйл ажиллагааны ТОВЧ ТАЙЛАН**

**2022 оны 3-р сар**

## 1. БИЗНЕСИЙН МОДЕЛЬ, СТРАТЕГИ

### Бизнесийн чиглэл

Оффис, агуулах, граж болон үйлдвэр үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйлчилгээ.

### Компанийн танилцуулга

Тус компани нь 1992 онд “Гутал” ХК нэртэйгээр үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдаж, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэгт байрлах оффис, агуулах болон үйлдвэр, үйлчилгээний зориулалттай объектуудыг түрээслүүлэх үйл ажиллагаа явуулж байна.

Тус компанийн үл хөдлөх эд хөрөнгө нь үйлдвэрийн барилга, гуанзны барилга, эмнэлгийн барилга, бусад жижиг барилгууд бүртгэлтэй байна. 2021 онд манай үйл ажиллагаа хэвийн нэг түвшинд явагдаж өнгөрлөө.

### Санхүүгийн байдал

“ГУТАЛ”ХК-ийн санхүүг 2018 оны 8-р сарын 01-ээс “ФИНАНСТАКС ” ТМЗ ХХК одоог хүртэл хариуцан ажиллаж ирлээ.

Компанийн үйлчилгээний борлуулалтын орлого, тэдгээртэй уялдан гарах бизнесийн үйл ажиллагааны зардлыг харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээ хэлцлийн дагуу сараар тооцож тайландаа тусгадаг билээ.

2021 оны компанийн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашгийн хэмжээ өнгөрөгч оныхоос 483.3 сая төгрөгөөр нэмэгдсэн.

### Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт /сая төгрөг/	2018	2019	2020	2021
Эргэлтийн хөрөнгө	3,995.3	4,876.0	4,445.9	5,479.9
Эргэлтийн бус хөрөнгө	7,878.7	8,156.7	8,322.6	8,036.9
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>11,874.0</b>	<b>13,032.7</b>	<b>12,768.5</b>	<b>13,516.8</b>
Өр төлбөр	753.6	782.4	816.1	967.5
Эзэмшигчийн өмч	11,120.4	12,250.3	11,952.4	12,549.3
<b>Нийт ӨТ ба ЭӨ-ийн дүн</b>	<b>11,874.0</b>	<b>13,032.7</b>	<b>12,768.5</b>	<b>13,516.8</b>

Нийт хөрөнгийн 92.9 хувийг эзний өмч, 7.1 хувийг өр төлбөр эзэлж байна.

### Орлогын тайлангийн үзүүлэлтүүд

2021 оны гүйцэтгэлээр 3,984.0 сая төгрөгийн орлоготой ажилласан.

Орлогын төрөл	2020	2021	Өсөлт /+/, бууралт -/	
			дүнгээр	хувиар
Түрээсийн орлого	3,672.5	3,944.8	272.3	7.4
Хүүгийн орлого	73.4	29.0	-44.4	-60.4
Бусад	2.4	10.2	7.8	325.0
Дүн	3,748.3	3,984.0	235.7	6.3

Тайлант жилд компани 2,248.4 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан нь өмнөх оноос 483.3 сая төгрөгөөр илүү байна. Түрээсийн орлого өмнөх оноос 272.3 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 2020, 2021 онд түрээсийн агуулахуудыг шинээр барьж ашиглалтанд оруулсан болон цар тахлын үеийн түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг 2021 оны 6 дугаар сараас зогсоосонтой холбоотой байна.

Үзүүлэлт /сая төгрөг/	2020 он	2021 он	Өсөлт /+/ Бууралт -/	Хувиар /%/
Нийт орлого	3,748.3	3,984.0	272.3	7.4
Нийт зардал	1,975.9	1,735.6	-240.3	-12.2
Татварын дараах цэвэр ашиг	1,765.1	2,248.4	483.3	27.4

#### Төлсөн татвар, шимтгэл

Тайлант жилд нэмэгдсэн өртгийн албан татварт 330.2, Нийгмийн даатгалын шимтгэлд 98.4, Хувь хүний орлогын албан татварт 44.3, суутгагчийн хувь хүнээс суутгасан албан татварт 85.4, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 92.9, нийт улс, орон нутгийн төсөвт 651.2 сая төгрөг төлсөн байна.

Төрөл /сая төгрөг/	2017	2018	2019	2020	2021
НӨАТ	302.0	435.7	341.4	303.8	330.2
НДШ	103.0	101.9	105.4	46.3	98.4
ХХОАТ	526.0	224.4	160.3	144.1	129.7
ААНОАТ	230.0	267.5	276.3	118.0	
ҮХЭХАТ	93.0	66.8	79.4	79.6	92.9
Нийт дүн	1,254.0	1096.3	962.8	691.8	651.2

## 2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Компанийн үйл ажиллагааг хууль тогтоомжинд нийцүүлэн явуулсаар ирсэн бөгөөд одоо ч энэхүү зарчимаа алдаагүй явуулж байна. Дэд бүтцийн хувьд цахилгаан, дулаан, ус, хот тохижилтын төвлөрсөн системд бүрэн холбогдсон учир эдгээр байгууллагуудтай аж ахуйн гэрээ байгуулан үйл ажиллагаагаа уялдуулан, мөрдөж буй норм нормотивыг баримтлан ажиллаж төлбөр тооцоог цаг тухайд нь хийж байна.

Нийгмийн халамжийн асуудлаар холбогдох хууль тогтоомж, компанийн ТУЗ-ийн шийдвэрийг баримтлан тодорхой төлөвлөгөөтэй ажил зохион явуулахаар төлөвлөн

хэрэгжүүлж ирлээ. Эдгээртэй холбогдон гарч буй зардлыг санхүүгийн төлөвлөгөөнд бүрэн тусгасан болно.

### 3. ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗҮГЭЭС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

1. Covid-19 цар тахлын дэгдэлттэй холбоотой эдийн засгийн хямралтай үед компанийн зүгээс алдагдал багатай зохион байгуулсан. Үүнд:

- 1.1 Түрээсийн төлбөрийн нөхцөлийг уян хатан байлгаж түрээсийн талбайн дүүргэлтийг хадгалж чадсан
- 1.2 Түрээсийн төлбөрийн хоцрогдол нэлээд үүссэнийг тухайн компаниудтай тулж ажиллаж түрээсийн төлбөрийн авлага үүсгээгүй
- 1.3 Нийт хамт олноороо халдварт өвчний эсрэг дэглэмийг чанд баримталж компанийн хүрээнд өвчлөлгүй даван гарч чадсан

2. Түрээсийн талбайг нэмэгдүүлсэн. Үүнд:

2.1 Удаан хугацаагаар хоосон байсан эмнэлгийн барилгын их засвар болон дулааны алдаатай барьсан 100 диаметртэй шугамыг 50 диаметртэй шугамаар шинээр сольж, гаднах талбайг нийтэд нь битондож автомашины зогсоол болгож Цэлмэг технологийн сургуульд түрээсүүлэхээр олон жилийн гэрээг хийж оруулсан. Мөн сургуультай урьдчилан тохиролцож оффисийн 7 давхар барилгын 1-6 дугаар давхрыг бүхэлд нь олон жилээр түрээслүүлэхээр болсон. Үүнд талбайн 30 хүртэл хувийг эзэлдэг нийтийн эзэмшлийн коридорыг нэмж төлбөртэй болгосон. Үүний үр дүнд түрээсийн орлого, үр өгөөж нэмэгдэнэ

2.2 Эмнэлгийн барилга, №32 дугаар агуулахын дундах зайг ашиглан 150 м2 дулаан агуулах шинээр барьж ашиглалтад оруулсан

3. Урсгал засвар. Үүнд:

3.1 Гутал ХК-н өөрийн мэдлийн сантехникийн узелийг 100 хувь засварласан

3.2 ТЗ-ын №5,6,7,8-р агуулах болон Цэцэрлэгийн сантехникийн шугам хоолойг шинээр сольсон

3.3 3 хүний орон тоотой барилгын засварын бригадыг бий болгож сүүлийн жилүүдэд хийгдээгүй урсгал засварын ажлыг нэг жилийн хугацаанд өвөл зунгүй тогтмол хийж байна. Барилгын материалын үнэ болон ажлын хөлс, нэмэгдэж олдоц муудаж байгаа энэ үед өөрийн үндсэн засварын ажилчидтай байгаа нь урсгал засвар хийх зардлыг хэмнэж, захиалгаар хийлгэснээс ажлын үр бүтээмж өндөртэй байна.

### 4. ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

“ГУТАЛ” ХК нь 2021 онд захиргааны албанд 5, инженер техникийн албанд 6, аж ахуй барилгын албанд 11, харуулын албанд 12 нийт 34 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулахаар төсөвлөсөн.

2021 онд ажилчдын ажлын үр дүнг сайжруулах, орон тооны илүүдлийг бууруулах зохистой арга хэмжээ авснаар цалингийн зардлын хэмжээг тодорхой хэмжээгээр хэмнэж ажилласан.

**ГУТАЛ ХК-ИЙН БҮТЭЦ ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТ**

